



ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



БАГАНУУР ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ

2017 оны эхний 12 сард



АГУУЛГА

	Хуудасны дугаар
 ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, 2013-2017 ОН	3
 АЖ ҮЙЛДВЭР	4
 НИЙГМИЙН ДААТГАЛ	6
 НИЙГМИЙН ХАЛАМЖ	7
 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙЧҮҮД	8
 ЭРҮҮЛ МЭНД	9
 ГЭМТ ХЭРЭГ	10
 НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	13
 НИЙТИЙН ТЭЭВЭР	14
 ШУУДАН ХОЛБОО	15
 ҮНЭ ХАНШ	16

ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хүснэгт 1. Малын тоо, 2017 оны жилийн эцэст, малын төрөл, хороогоор

Үзүүлэлт	Дүүргийн дүн	Үүнээс: хороогоор				
		1	2	3	4	5
Нийт мал	172049	42856	11964	43683	47027	26519
Үүнээс:						
Тэмээ	224	70	-	152	2	-
Адуу	13391	3882	696	3354	3092	2367
Үхэр	14563	3947	1221	3344	3631	2420
Хонь	88526	21268	6129	22426	25634	13069
Ямаа	55345	13689	3918	14407	14668	8663

Хүснэгт 2. Хүн ам зүйн үзүүлэлт

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2013 I-XII	2014 I-XII	2015 I-XII	2016 I-XII	2017 I-XII
Суурин хүн ам	тоо	27936	28333	28419	28973	28787 [*]
Төрөлт	тоо	850	765	722	606	609
Нас баралт	тоо	176	194	188	169	149
Шилжиж ирсэн	тоо	1280	1139	1196	1036	709
Шилжиж явсан	тоо	1383	1365	1438	1325	1355
Цэвэр өсөлт	хувь	2.41	2.02	1.88	1.51	1.60
Механик өсөлт	хувь	-0.37	-0.80	-0.85	-1.00	-2.24

^{*} – урьдчилсан гүйцэтгэл



АЖ ҮЙЛДВЭР


Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэлт 2017 оны 4-р улиралд 126.0 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 13.4 тэрбум төгрөгөөр (11.9%) нэмэгдсэн байна.

Хүснэгт 3. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт


Үзүүлэлт	Хэмжих нэгж	Биет хэмжээ			Үнийн дүн, сая төгрөг		
		2016 I-XII	2017 I-XII	$\frac{2017}{2016} \%$	2016 I-XII	2017 I-XII	$\frac{2017}{2016} \%$
Нүүрс олборлолт	м.тн	3 913.8	4 019.4	102.7	107 629.5	118 572.3	110.2
Дулаан дамжуулалт	м.гкал	155.9	168.0	107.8	4 505.1	4 836.4	107.4
Талх үйлдвэрлэлт	тн	128.3	137.4	107.1	167.0	192.2	115.1
Нарийн боов үйлдвэрлэлт	тн	162.9	73.9	45.4	321.2	312.6	97.3
Арматур үйлдвэрлэлт	тн	-	1 650.0	-	-	2 081.3	-

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн биет хэмжээг өмнөх оны мөн үетэй харьцуулахад нүүрс олборлолт 105.6 мянган тонноор (2.7%), дулаан дамжуулалт 12.1 мянган гкалаар (7.8%), талх үйлдвэрлэлт 9.1 тонноор (7.1%) тус тус өссөн бол нарийн боов үйлдвэрлэлт 89.0 тонноор (54.6%) буурсан байна. Тайлант хугацаанд 1650 тонн барилгын арматур үйлдвэрлэгдсэн байна.


Зураг 1. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, сая төгрөг, сараар



Зураг 2. Талх, нарийн боов үйлдвэрлэлт, сараар, мянган төгрөг



Зураг 3. Нүүрс олборлолт, мянган тонн, жил бүрийн 4-р улиралд



Харин аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийг үнийн дүнгээр өмнөх оны мөн үетэй харьцуулахад нүүрс олборлолт 10942.8 сая төгрөгөөр (10.2%), дулаан дамжуулалт 331.4 сая төгрөгөөр (7.4%), талх үйлдвэрлэлт 25.2 сая төгрөгөөр (15.1%) тус тус өссөн бол нарийн боов үйлдвэрлэлт 8.6 сая төгрөгөөр (2.7%) буурсан байна.




НИЙГМИЙН ДААТГАЛ

2017 оны эхний 12 сард нийгмийн даатгалын сангийн орлого 14730.1 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс 2466.0 сая төгрөгөөр (20.1%), зарлага 23257.1 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс 1469.5 сая төгрөгөөр (6.7%) тус тус өссөн байна.

Нийт орлогын 8722.8 сая төгрөг (59.2%) тэтгэврийн сангаас, 987.4 сая төгрөг (6.7%) тэтгэмжийн сангаас, 1528.0 сая төгрөг (10.4%) ҮОМШӨ сангаас, 3262.5 сая төгрөг (22.1%) эрүүл мэндийн даатгалын сангаас, 229.4 сая төгрөг (1.6%) ажилгүйдлийн сангаас тус тус төвлөрсөн байна.


Зураг 4. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, сараар



Хүснэгт 4. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2016		2017		$\frac{2017.XII}{2016.XII}\%$	$\frac{2017.I-XII}{2016.I-XII}\%$
	XII	I-XII	XII	I-XII		
Сангийн орлого, бүгд	1237.4	12264.1	2294.6	14730.1	185.4	120.1
тэтгэврийн сан	672.0	7293.0	1400.8	8722.8	208.5	119.6
тэтгэмжийн сан	71.9	815.5	155.4	987.4	216.1	121.1
ажилгүйдлийн сан	17.9	201.5	36.8	229.4	205.6	113.8
ҮОМШӨ-ний сан	113.6	1287.1	242.1	1528.0	213.1	118.7
ЭМД-ын сан	362.0	2667.0	459.5	3262.5	126.9	122.3
Сангийн зарлага, бүгд	2012.3	21787.6	2118.9	23257.1	105.3	106.7
тэтгэврийн сан	1307.1	14935.4	1361.7	16054.5	104.2	107.5
тэтгэмжийн сан	78.2	810.2	82.2	938.9	105.1	115.9
ҮОМШӨ-ний сан	164.6	1890.0	152.2	1855.1	92.5	98.2
ЭМД-ын сан	424.9	3799.0	500.4	4051.6	117.8	106.6
ажилгүйдлийн сан	37.5	353.0	22.4	357.0	59.7	101.1

Зураг 5. Нийгмийн даатгалын сангийн зарлагын бүтэц



Тайлант хугацаанд нийгмийн даатгалын сангаас 4099 хүнд 16054.5 сая төгрөгийн тэтгэвэр, 3399 хүнд 938.9 сая төгрөгийн тэтгэмж, 1072 хүнд 1855.1 сая төгрөгийн үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний тэтгэмж, 152127 хүнд 4051.6 сая төгрөгийн эрүүл мэндийн даатгал, 209 хүнд 357.0 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж тус тус олгосон байна.




НИЙГМИЙН ХАЛАМЖ

2017 оны эхний 12 сард нийгмийн халамжийн сангийн орлого 2678.0 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс 353.4 сая төгрөгөөр (15.2%) өссөн байна.

Нийгмийн халамжийн сангийн нийт орлогын 532.3 сая төгрөг (19.8%) улсын төсвөөс, 2139.9 сая төгрөг (80.0%) орон нутгийн төсвөөс, 5.8 сая төгрөг (0.2%) бусад орлогоор тус тус санхүүжигдсэн байна.

Зураг 6. Нийгмийн халамжийн сангийн зарлагын бүтэц



Тайлант хугацаанд нийгмийн халамжийн сангаас 536 хүнд 763.5 сая төгрөгийн тэтгэвэр, 637 хүнд 398.0 сая төгрөгийн тэтгэмж, 1191 жирэмсэн эхчүүдэд 289.1 сая төгрөгийн тэтгэмж, “Алдарт эх”-ийн одонтой 2087 эхчүүдэд 280.0 сая төгрөг, 1287 ахмадуудад 211.5 сая төгрөгийн насны хишиг олгосон байна.

Ахмад дайчин, гавьяат цолтой 18 хүнд 34.3 сая төгрөг, 2702 ахмад настанд 276.4 сая төгрөгийн хөнгөлөлт үзүүлж, 2804 хүнийг хүнс тэжээлийн хөтөлбөрт хамруулж 192.4 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй 499 иргэдэд 124.5 сая төгрөгийн хөнгөлөлт тус тус олгосон байна.

Хүснэгт 5. Нийгмийн халамжийн сангийн орлого, зардал, сая төгрөг

Үзүүлэлт	2016		2017		$\frac{2017.XII}{2016.XII} \%$	$\frac{2017.I-XII}{2016.I-XII} \%$
	XII	I-XII	XII	I-XII		
Сангийн орлого	219.8	2324.6	251.9	2678.0	114.6	115.2
Улсын төсвөөс	6.0	348	2.3	532.3	37.5	153.0
Орон нутгийн төсвөөс	213.6	1970.4	249.3	2139.9	116.7	108.6
Бусад орлого	0.2	6.2	0.3	5.8	140.6	93.4
Сангийн зарлага	243.7	2304.2	294.3	2667.0	120.8	115.7
Тэтгэвэр	66.6	746.7	63.9	763.5	95.9	102.3
Тэтгэмж	36.5	399.7	32.2	398.0	88.2	99.6
"Алдарт эх" I одонт эхчүүд	-	144.8	0.4	140.1	-	96.8
"Алдарт эх" II одонт эхчүүд	0.8	135.0	1.1	139.8	142.5	103.6
Жирэмсэн эхчүүдийн тэтгэмж	27.5	304.8	27.6	289.1	100.2	94.9
Насны хишиг	-	-	0.3	211.5	-	-
Ахмад дайчин, гавьяатын нэмэгдэл	3.1	42.3	2.4	34.3	78.7	81.0
Ахмад настанд үзүүлсэн хөнгөлөлт	45.5	221.6	34.3	276.4	75.4	124.8
ХБИ-д үзүүлсэн хөнгөлөлт	19.7	107.3	17.2	124.5	87.5	115.9
“Хүнс тэжээл” халамжийн хөтөлбөр	12.6	145.1	68.2	192.4	5.4*	132.6
ОНО-д түшиглэсэн халамж	-	12.0	33.5	78.3	-	6.5*
Бусад үйлчилгээ	31.5	44.9	13.1	19.1	41.6	42.5


*дахин их



БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД


2017 оны 12 сарын эцэст дүүргийн хэмжээнд ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэд 357 бүртгэгдсэний 191 (53.5%) нь эмэгтэйчүүд байна.

Зураг 7. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн хөдөлгөөн



Тайлант сард ажил идэвхтэй хайж байсан 373 иргэн шинээр бүртгүүлсэн бөгөөд үүнээс 227 (60.9%) нь эмэгтэйчүүд байна. Мөн энэ хугацаанд 173 иргэн ажилд зуучлуулан орсон ба хязгаарлагдмал хариуцлагатай компанид 8, бусад хэлбэрийн байгууллагад 165 иргэн тус тус ажилд орсон байна.

Зураг 8. Бүртгэлтэй ажилгүй иргэд, насны бүлгээр



2017 оны 12-р сард ажил идэвхтэй хайж байгаа иргэдийн 78 (21.8%) нь 16-24 насны, 136 (38.1%) нь 25-34 насны залуучууд, 71 (19.9%) нь 35-44 насныхан, 64 (17.9%) нь 45-60 насны, 8 буюу (2.2%) нь 60-аас дээш насны ажилгүй иргэд байна.

Ажил идэвхтэй хайж буй иргэдийн 105 нь (29.4%) дээд боловсролтой, 20 нь (5.6%) тусгай дунд боловсролтой, 23 нь

(6.4%) мэргэжлийн анхан шатны боловсролтой, 197 нь (55.2%) бүрэн дунд боловсролтой, 9 нь (2.5%) бүрэн бус дунд боловсролтой, 3 нь (0.9%) бага болон боловсролгүй ажээ.



ЭРҮҮЛ МЭНД

Дүүргийн хэмжээнд 2017 оны эхний 12 сард 591 эх амаржиж, 595 хүүхэд төрүүлснээс бусад аймаг орон нутаг, дүүргийн харьяат 129 эх амаржсан байна. Энэ хугацаанд 234475 хүн үзлэгт хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 2725 хүнээр (1.5%) буурсан бол 8312 хүн хэвтэн эмчлүүлсэн байгаа нь өмнөх оны мөн үеэс 222 хүнээр


(2.7%) өссөн байна.

Хүснэгт 6. Бүртгэгдсэн халдварт өвчин

Үзүүлэлт	2016 I-XII	2017 I-XII	Өсөлт бууралт
Халдварт, паразит өвчин	233	177	-56
Заг хүйтэн	92	56	-36
Тэмбүү	73	62	-11
Мөөгөнцөр /кандидоз/	13	10	-3
Трихомониаз	49	47	-2
Кандилом	5	2	-3
Халамид	1	-	-1
Цочмог халдварт өвчин	565	241	-324
Цусан суулга	6	25	19
Гепатит А	7	5	-2
Скарлатин	11	6	-5
Салхин цэцэг	84	113	29
Крансух	4	1	-3
Гахайн хавдар	1	1	-
Корь	354	1	-353
Сальмонеллез	-	1	1

Хачигт рикеттиоз	2	1	-1
Рож	3	5	2
Гар хөл амны өвчин	67	60	-7
Сүрьеэ	26	22	-4
Нийт халдварт өвчин	798	418	-380

Зураг 9. Халдварт өвчин, сараар



2017 оны эхний 12 сард халдварт паразит өвчний 177 тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний 42.3%-ийг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 56 тохиолдлоор (24.0%), цочмог халдварт өвчний 241 тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний 57.7%-ийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 324 тохиолдлоор (57.3%) тус тус буурсан байна.

Дүүргийн дунджаар 10000 хүн тутамд ногдох халдварт өвчнөөр өвчлөгсдийн тоо 145.7 байгаа нь өмнөх оны мөн үеэс 135.1 продицмиллээр буурчээ.



ГЭМТ ХЭРЭГ

2017 оны 4-р улиралд дүүргийн хэмжээнд 254 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 39 хэргээр (13.3%) буурчээ. Гэмт хэргийн илрүүлэлт 49.4 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 23.6 пунктээр доогуур байна.

Хүснэгт 7. Бүртгэгдсэн гэмт хэрэг

Хэргийн төрөл	2016 I-XII	2017 I-XII	Хэргийн өсөлт		Дүнд эзлэх хувь
			тоо	хувь	
Бүртгэгдсэн гэмт хэрэг, бүгд	293	254	-39	-13.3	100.0
Хүний амь	1	1	-	-	0.4
Хүчин	7	5	-2	-28.6	2.0
Дээрэм	3	3	-	-	1.2
Танхай	13	4	-9	-69.2	1.6
ББМГУчруулах	114	106	-8	-7.0	41.7
Ашиглах	4	-	-4	-100.0	-
Хулгай	71	74	3	4.2	29.1

Үүнээс: малын	4	8	4	100.0	10.8'
Залилан	12	17	5	41.7	6.7
ХАБЭсрэг	36	11	-25	-69.4	4.3
Бусад	32	33	1	3.1	13.0
Хэрэг илрүүлэлтийн хувь	73.0	49.4			

‘-малын хулгайн хэргийг нийт хулгайн хэрэгт эзлэх хувиар тооцсон.


Бүртгэгдсэн гэмт хэргийн 41.7 хувийг бусдын бие махбодид гэмтэл учруулах, 29.1 хувийг хулгайн, 6.7 хувийг залилан, 4.3 хувийг хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг, 2.0 хувийг хүчин, 1.6 хувийг танхай, 1.2 хувийг дээрэм, 0.4 хувийг хүн амины хэрэг, 13.0 хувийг бусад гэмт хэрэг эзэлж байна.

2017 оны 4-р улиралд малын хулгайн хэрэг 8 бүртгэгдсэн нь нийт хулгайн гэмт хэргийн 10.8 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 4 хэргээр нэмэгджээ.

Хүснэгт 8. Гудамж талбайд болон согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг

Хэргийн төрөл	2016 I-XII		2017 I-XII	
	согтуугаар	гудамж талбайд	согтуугаар	гудамж талбайд
Бүгд	91	53	85	48
Хүний амь	1	-	1	-
Хүчин	5	-	4	1
Дээрэм	-	-	1	3
Танхай	10	5	2	1
ББМГУчруулах	66	36	67	27
Хулгай	4	7	1	6
Залилан	-	1	-	1
ХАБЭсрэг	1	-	1	-
Гэр бүлийн хүчирхийлэл	-	-	3	-
Бусад	4	4	5	9
Дүнд эзлэх хувь	31.1	18.1	33.5	18.9


Зураг 10. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг, жил бүрийн 4-р улиралд



Тайлант хугацаанд согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 85 болж өмнөх оны мөн үеэс 5 хэргээр (6.3%) өссөн бол гудамж талбайд 48 хэрэг үйлдэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 5 хэргээр (9.4%) буурсан байна.

Харин согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг нийт гэмт хэргийн 33.5 хувийг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 2.4 пунктээр, гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг нийт хэргийн 18.9 хувийг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 0.8 пунктээр тус тус нэмэгдсэн байна.

Зураг 11. Гудамж талбайд болон согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн эзлэх хувь, жил бүрийн 4-р улиралд



2017 оны 4-р улиралд гэмт хэрэгт 202 иргэн холбогдон шалгагдсаны 19 нь (9.4%) 18 хүртлэх насны хүүхэд, 54 нь (16.3%) эмэгтэйчүүд байна.

Хүснэгт 9. Гэмт хэрэгт холбогдсон хүмүүс


Үзүүлэлт	Хүний тоо		Өсөлт, бууралт	
	2016 I-XII	2017 I-XII	тоо	хувь
Гэмт хэрэгт холбогдсон хүн	318	202	-116	-36.5
Үүнээс: эмэгтэйчүүд	56	33	-23	-41.1
хүүхэд	14	19	5	35.7
Гэмт хэргийн улмаас хохирсон хүн	302	261	-41	-13.6
Үүнээс: нас барсан	12	7	-5	-41.7
гэмтсэн	175	132	-43	-24.6
Саатуулагдсан хүний тоо	1763	2162	399	22.6
Баривчлагдсан хүний тоо	78	188	110	141.0
Учирсан хохирол /сая төгрөг/	279.3	276.1	-3.2	-1.1
Нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ /сая төгрөг/	123.5	160.0	36.5	29.6

Зураг 12. Гэмт хэргийн улмаас хохирсон, гэмтсэн, нас барсан хүн, улирлаар



Тайлант хугацаанд 261 хүн гэмт хэргийн улмаас хохирсон ба үүнээс 132 хүн гэмтэж, 7 хүн нас барсныг өмнөх оны мөн үетэй харьцуулахад гэмтсэн хүн 43 нэгжээр (24.6%) нас барсан хүн 7 нэгжээр (41.7) тус тус буурсан байна. Мөн 2162 хүн саатуулагдаж, 188 хүн баривчлагдсан нь өмнөх оны мөн үеэс саатуулагдсан хүний тоо 399 хүнээр (22.6%), баривчлагдсан хүний тоо 110 хүнээр (2.4 дахин) тус тус өссөн байна.

Зураг 13. Гэмт хэрэгт холбогдсон иргэдийн бүтэц



Гэмт хэргийн улмаас 276.1 сая төгрөгийн хохирол учирсны 160.0 сая төгрөгийг (58.0%) нөхөн төлүүлжээ.



НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ


Тайлант хугацаанд нийтийн аж ахуй үйлчилгээний салбарын орлого 1563.7 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс 44.8 сая төгрөгөөр (2.8%) буурсан байна. Нийт орлогын 977.1 сая төгрөгийг (62.5%) хүн амаас оруулсан орлого эзэлж байна.

Хүснэгт 10. Орон сууц нийтийн аж ахуйн орлого, сая төгрөг

Үзүүлэлт	2016 I-XII	2017 I-XII	Өсөлт бууралт
Нийт орлого	1608.5	1563.7	-44.8
Орон сууц	127.8	135.3	7.5
Ус борлуулалт, бүгд	748.9	711.0	-37.9
хүн амд	406.2	392.7	-13.5

аж ахуйн нэгжид	328.9	309.8	-19.1
үйлчилгээний байгууллагад	13.8	8.5	-5.3
Сувагжуулалт	589.1	542.2	-46.9
Бусад	142.6	175.2	32.6

Зураг 14. Нийтийн үйлчилгээний салбарын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл, сая төгрөг



Хүснэгт 11. Сууц өмчлөгчдийн холбоодын орлогын биелэлт, мянган төгрөг

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	ТБ%
Нийт дүн	369637.3	359203.5	97.2
Үүнээс:			
Тавлаг өргөө	82019.6	74580.4	90.9
Маргад өргөө	73943.5	72889.2	98.6
Сод хөгжил	101113.2	92821.3	91.8
Шинэ элч	63419.0	76280.3	120.3
Уурхайчин	49142.0	42632.3	86.8



НИЙТИЙН ТЭЭВЭР:

2017 оны 4-р улиралд нийтийн тээврийн салбар 35022.8 мянган хүн километрийн ажил үйлчилгээг гүйцэтгэн, давхардсан тоогоор нийтдээ 283.1 мянган хүн тээвэрлэж, 929.8 сая төгрөгийн орлоготой ажилласан байна.

Хүснэгт 12. Тээврийн салбарын гол үзүүлэлт

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2014 I-XII	2015 I-XII	2016 I-XII	2017 I-XII	$\frac{2017}{2016}$ %
Нийт орлого	сая.төгрөг	674.2	1025.1	866.5	929.8	107.3
Тээсэн зорчигч	мян.хүн	197.7	186.1	202.7	283.1	139.7
Зорчигч эргэлт	мян.хүн.км	26689.5	25123.5	27364.5	35022.8	128.0

Өмнөх оны мөн үеэс зорчигчдын тоо 80.4 мянган хүнээр (39.7%), үйлчилгээний орлого 63.3 сая төгрөгөөр (7.3%) тус тус нэмэгдсэн байна.




ШУУДАН ХОЛБОО:

Шуудан холбооны үйлчилгээний орлого 2017 оны 4-р улиралд 407.6 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс 24.7 сая төгрөгөөр (6.5%), хүн амаас орсон орлого 232.4 сая төгрөг болж 16.2 сая төгрөгөөр (7.5%) тус тус өссөн байна. Нийт орлогын 57.0 хувийг хүн амаас орсон орлого эзэлж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.5 пунктээр нэмэгдсэн байна.


Хүснэгт 13. Шуудан холбооны үзүүлэлтүүд

Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2014 I-XII	2015 I-XII	2016 I-XII	2017 I-XII	$\frac{2017}{2016} \%$
Холбооны үйлчилгээний орлого	сая төг	499.3	419.0	382.9	407.6	106.5
Үүнээс: хүн амаас орсон орлого	сая төг	286.0	256.5	216.2	232.4	107.5
Суурин телефон цэг	тоо	723	652	703	659	93.7
Үүнээс айл өрхийн	тоо	305	235	299	256	85.6

Зураг 15. Суурин телефон цэгийн тоо




Зураг 16. Шуудан холбооны үйлчилгээний орлого, сая төгрөг



Тайлант хугацаанд суурин телефон цэгийн тоо 659 болж өмнөх оны мөн үеэс 44 цэгээр, (6.7%) үүнээс айл өрхийн хэрэглэгчдийн тоо 256 болж өмнөх оноос 43 цэгээр (14.4%) тус тус буурсан байна.

Шуудангийн үйлчилгээний салбар 2017 оны 4-р улиралд 16.4 мянган ширхэг бичиг захидал, 1.9 мянган ширхэг илгээмж, 111.0 мянган ширхэг тогтмол хэвлэлийг хэрэглэгчдэд хүргэсэн байна.



ҮНЭ ХАНШ


2017 оны 12 сарын хүнсний өргөн хэрэглээний 21 нэр төрлийн бүтээгдэхүүний дундаж үнийг ажиглахад доорх байдалтай байна.

Хүснэгт 14. Хүнсний барааны үнийн ажиглалт, 2017 оны 12 сарын дундаж үнэ


№	Хүнсний бараа		Хэмжих нэгж	Хишиг-Уул супер маркет	Марал хүнсний дэлгүүр	Хэрлэн хүнсний зах	В&М супер маркет	Шинэ зах
1	"Алтан тариа" гурил	Дээд	кг	1400	1300		1300	1300
		I зэрэг	кг	1100	1100		1100	1100
		II зэрэг	кг	900	900		900	900
2	Будаа	цагаан	кг	2350	2100		2200	2300
		шар	кг	1200	1200		1200	1200
3	Хонины мах	ястай	кг			5125		5125
		цул	кг			6125		6125
4	Үхрийн мах	ястай	кг			6500		6500
		цул	кг			7500		7500
5	Адууны мах, ястай		кг			5625		5625
6	Ямааны мах		кг			4250		4250
7	Элсэн чихэр		кг	2150	2200		2300	2200
8	Сүү /задгай/		л	1675				
9	Тараг /задгай/		л	-				
10	Цөцгийн тос, Орос		кг	3500	3400		3400	
11	Байцаа		кг			1475	1475	1475
12	Манжин		кг			2800	2800	2800
13	Төмс	монгол	кг			875	900	888
14	Лууван	монгол	кг			1375	1425	1400
15	Сонгино	хятад	кг			1150	1150	1175
		монгол	кг			2250	2325	2250
16	Сармис, булцуу		ш			500	500	500
17	Огурцы, хятад		кг			5000	5000	5000
18	Помидор, хятад /үрлэн/		кг			5625	5625	5625
19	Ургамлын тос/ sunny gold/		ш	3550	3450		3500	3500
20	Өндөг		ш	380	350		350	330
21	Талх бури	том 900 гр	ш	1600	1600		1600	1600
		Дунд 700 гр	ш	1400	1400		1400	1400

жижиг 500 гр	ш	1100	1100	1100	1100
Есөн шанд /дунд/	ш	1500	1500	1500	1500
Атар талх	ш	1200	1200	1200	1200

Зураг 17. “Алтан тариа” гурилын үнэ, жил бүрийн 12-р сард



Зураг 18. Нэг кг цул махны үнэ, жилийн бүрийн 12-р сард



Хүснэгт 15. Үйлчилгээний үнийн тариф, (НӨТ-гүй үнэ)

Үзүүлэлт	Хэмжин нэгж	Айл өрхөд (төгрөг)	Хэмжин нэгж	Аж ахуйн нэгж байгууллагад (төгрөг)
Дулаан	1м ²	600	1м ³	983
Дулааны суурь тариф	40 м ² хүртэл	3 000	-	-
	40м ² - 80м ²	5 000		
	81м ² -аас дээш	10 000		
Халуун ус	Өвөл		1 гкал	69 647
	1 хүн (тоолуургүй)	2 875		
	1м ³ (тоолууртай)	1 484		
	Зун			
	1 хүн (тоолуургүй)	4 025		
	1м ³ (тоолууртай)	1 484		

Цэвэр ус*	1 хүн (тоолуургүй)	0.8	1 л (тоолуургүй)	1.50
	1 л (тоолууртай)	0.65	1 л (тоолууртай)	1.20
	суурь хураамж	1 800	1 л (зөөврөөр)	5.45
Бохир ус*	1 хүн (тоолуургүй)	0.77	1 л (тоолуургүй)	1.50
	1 л (тоолууртай)	0.63	1 л (тоолууртай)	1.20

*2017 оны 9 сарын 15-наас мөрдөж байгаа тариф

Хүснэгт 16. Цахилгааны үнийн тариф, (НӨТ-гүй үнэ)

Хэрэглэгчдийн ангилал	Хэмжих нэгж	Тариф (НӨАТ-гүй)
* Айл өрхөд борлуулах цахилгааны тариф		
Энгийн тоолууртай		
Сарын нийт хэрэглээний 150 кВт.ц	төг/квт.ц	98.4
Сарын нийт хэрэглээний 151 кВт.ц-аас дээш	төг/квт.ц	118.2
2 тарифт тоолууртай		
Өдрийн хэрэглээ /06.00-21.00/	төг/квт.ц	104.3
Орой, шөнийн хэрэглээ /21.00-06.00/	төг/квт.ц	77.1
Сарын суурь тариф	төг/сар	2 000.0
* Аж ахуйн нэгж, байгууллагад борлуулах цахилгааны тариф		
Энгийн тоолууртай		
Өдрийн хэрэглээ /06.00-17.00/	төг/квт.ц	128.5
Оройн хэрэглээ /17.00-24.00/	төг/квт.ц	209.8
Шөнийн хэрэглээ /24.00-06.00/	төг/квт.ц	77.1
3 тарифт тоолууртай /уул уурхай, үйлдвэрийн газар/		
Өдрийн хэрэглээ /06.00-17.00/	төг/квт.ц	155.9
Оройн хэрэглээ /17.00-24.00/	төг/квт.ц	276.0
Шөнийн хэрэглээ /24.00-06.00/	төг/квт.ц	77.1

* 2015 оны 7 сарын 25-ны өдрөөс мөрдөж буй тариф


Хүснэгт 17. Түлш шатахууны үнэ

Шатахууны нэр төрөл	2017.I	2017.II	2017.III	2017.IV	2017.V	2017.VI
АИ -76,80	1 480	1 480	1 480	1 480	1 480	1 480
АИ -92,93	1 630	1 630	1 630	1 630	1 630	1 630
Дизель түлш	1 720	1 720	1 720	1 720	1 720	1 720
	2017.VII	2017.VIII	2017.IX	2017.X	2017.XI	2017.XII
АИ -76,80	1 480	1 480	1 480	1 480	1 480	1 480
АИ -92,93	1 630	1 630	1 630	1 630	1 630	1 630
Дизель түлш	1 720	1 720	1 720	1 720	1 720	1 720

СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

2018 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр

СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙГ ХЭРХЭН АВАХ ВЭ?



 Цахимаар:

www.1212.mn

Статистик мэдээллийн
нэгдсэн сан



www.nso.mn

Та статистик мэдээллийг байнга
авч байхыг хүсвэл **ЭНД ДАРЖ**
бүртгүүлнэ үү

Энэ хэсэгт өөрийн e-mail
хаягаа бүртгүүлснээр
статистикийн мэдээллийг
цаг алдалгүй тогтмол авч
байх болно.

SOCIAL NETWORK



[www.facebook.com/
Статистик-Мэдээлэл](http://www.facebook.com/Статистик-Мэдээлэл)



[www.twitter.com/
statistic_mn](http://www.twitter.com/statistic_mn)



Ухаалаг гар утас, таблет
ашиглан статистик мэдээлэл
авах **ezStat** аппликейшн



Статистикийн хэвлэмэл
бүтээгдэхүүнийг унших
Монстат аппликейшн



Download on the
App Store

 **Google play**



Утсаар:



Лавлах утас

1900-1212